



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 12 дугаар сарын 11 өдөр

Дугаар 93

Хэрлэн сум

LXLIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 93 дугаар хуралдаан 2021 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 16:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 85,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Малын гоц халдварт өвчний нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

*Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат
Мал эмнэлгийн газар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.1. Аймгийн Онцгой комиссын 2021 оны 93 дугаар хуралдаанаар хэлэлцсэн үхрийн арьс товруутах өвчин болон цагаан зээрийг хамгаалах чиглэлээр гарсан саналыг Улсын Онцгой комисст албан бичгээр уламжлах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,


Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн, хурандаа Б.Бямбаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтүяа,

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа,

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Гантулга нарт:

1.2. Үхрийн арьс товруутах өвчний устгалын ажлыг Баянтүмэн суманд Мал эмнэлгийн газар, Гурванзагал суманд Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар, Дашбалбар суманд аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат, Халхгол суманд

 / М.Бадамсүрэн
Хур Г.Нармандах

Мэргэжлийн хяналтын газар, Чулуунхороот суманд Цагдаагийн газар, Чойбалсан суманд Тагнуулын газар, Цагаан-Овоо суманд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нар хариуцан зохион байгуулж, хяналт тавьж ажиллах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Гантулга нарт:

1.3.Малын гоц халдварт шүлхий өвчний хорио цээрийн дэглэм тогтоосон сумдад ажиллах аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргаар ахлуулсан ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагуудын албан хаагч нарыг томилж ажиллуулах,

Мал эмнэлгийн газрын Захиргаа, санхүү албаны дарга Н.Мөнхнайрамдал-д:

1.4.Сумдын мал эмнэлгийн тасгийн хүний нөөц, боловсон хүчний талаар бусад мэргэжлийн байгууллагуудтай мэдээлэл солилцож, сумдад мэргэжлийн албан хаагчийг томилж ажиллуулах асуудлыг шийдвэрлэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа,
АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа нарт:

1.5.Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх чиглэлээр томилогдож ажилласан аж ахуйн нэгж, албан хаагч нарын томилолт, шатахууны зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг тус тус үүрэг болгов.

ДАРГА

М.БАДАМСҮРЭН

ОРЛОГЧ ДАРГА,
ХУРАНДАА

Г.НАРМАНДАХ

